

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ШААРАВ ОВОГТОЙ ОТГОНБАЯРЫН  
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 оны 07 дугаар сарын 24

**Нэг:ШУДАРГА ТӨР**

Төрийн албаны удирдлага, албан хаагчдын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, ил тод шуурхай хариуцлагатай байх зарчмыг удирдлага болгон авлига, хүнд сурталгүй иргэд, олон нийтийн оролцоог хангасан сайн засаглалыг хэрэгжүүлж, иргэддээ тэгш шударга үйлчилдэг нийтийн албыг бэхжүүлнэ.

**1.1 Нээлттэй ухаалаг засаглал**

1.1.1.Төрийн бодлогыг урт хугацаанд төлөвлөдөг,тасралтгүй,тогтвортой ажилладаг тогтолцоог бүрдүүлнэ.

1.1.2.Төрийн албан хаагч тухайн салбартаа бизнесийн үйл ажиллагаа эрхэлдэггүй бизнесийн тогтолцоог бий болгоно.

1.1.3.Төсвийн зардал зарцуулалтыг иргэд хянадаг нээлттэй засаглал,"Шилэн данс"-ны тогтолцоог сэргээж хэрэгжүүлнэ.

1.1.4.Хүчтэй төрөөс илүү ухаалаг төр байх чиглэлд санаачилга гаргана.

1.1.5.Орон нутагт улс төржилтийг бууруулна.

1.1.6.Аймаг,сум,багийн нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг улс төрөөс ангид байлгах чиглэлд анхаарч ажиллана.

**1.2. Төрийн хүний нөөцийн зөв бодлого**

1.2.1.Төрийн албанд "Мерит" зарчимд тулгуурласан хүний нөөцийн бодлого,сонгон шалгаруулалтын тогтолцоог бий болгож хэвшүүлнэ.

1.2.2.Ялсан нам төрийн албыг үймүүлдэг,төрийн албан хаагчдыг халж сольдог буруу тогтолцоог халахын төлөө ажиллана.

1.2.3.Төрийн албыг чадварлаг,туршлагатай,сэтгэлтэй хүмүүсээс бүрдсэн цомхон багаар ажиллах бүтцэд шилжүүлэхийн төлөө ажиллана.

1.2.4.Төрийн албан хаагчыг сургах,хөгжүүлэх,ахих дэвших хүний хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх эдийн засаг,эрх зүйн орчныг бий болгоход манлайлан ажиллана.

1.2.5.Төрийн алба,төрийн албан хаагчын хариуцлагыг дээшлүүлэх эрх зүйн орчин,хяналтын тогтолцоог бий болгоно.



Official red stamp and signature of the State Court of the Republic of Mongolia.

1.2.6.Төрийн тусгай албаны чиг үүрэг,үйл ажиллагааг иргэнд үйлчлэх,иргэнээ хамгаалах чиглэл рүү өөрчлөх тогтолцоог бий болгоно.

### **1.3. Ухаалаг гадаад харилцаа**

1.3.1.Төвийг сахисан гадаад бодлогыг тууштай дэмжинэ.

1.3.2.Бүс нутгийн улс төр,нийгэм эдийн засгийн интеграцид харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэхийг дэмжинэ.

1.3.3.Гуравдагч хөршийн эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажилд дэмжиж ажиллана.

1.3.4.Экспортыг нэмэгдүүлэх,хөрөнгө оруулалтыг татах бодлогыг гадаад бодлогын цөм болгоход чиглэж ажиллана.

1.3.5.Хил залгаа хөрш орнуудтай харилцан тэнцвэртэй хамтран ажиллах бодлогыг дэмжин ажиллана.

1.3.6.Хөрш орнуудаас хамаарал бүхий дэд бүтэц,хөрөнгө оруулалт,эдийн засгийн салбаруудын хамаарлыг бууруулах геополитикийн бодлого бий болгох чиглэлд ахиц гаргах хэмжээнд санаачлагатай ажиллана.

## **ХОЁР:БҮТЭЭЛЧ ЭДИЙН ЗАСАГ**

### **2.1.Бүтээлч,тогтвортой эдийн засаг.**

2.1.1.Эдийн засгийн олон тулгуурт хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө ажиллана.

2.1.2.Аялал жуулчлал,ХАА-н салбарыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгох бодлого,хууль эрх зүйн орчныг бий болгох чиглэлд манлайлж ажиллана.

2.1.3.Хүнс хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн салбарыг бие даасан,бусад улс орноос хамааралгүй болоход анхаарч өрсөлдөх чадварыг бэхжүүлнэ.

2.1.4.Хөдөө аж ахуйн кластер бий болгох бодлого эрх зүйн таатай орчныг бий болгоно.

2.1.5.Малчдын орлогыг нэмэгдүүлэх,малын үүлдэр угсаагаа сайжруулах чиглэлийн ажлыг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан,Мал хамгаалах сангийн зээлтэй холбож өгнө.

2.1.6.Байгальд ээлтэй газар тариалангийн бодлогыг дэмжинэ.

2.1.7."Монгол бэлчээрийн мах"-ны брэндийг дэлхийг таниулах чиглэлд бодлого хөтөлбөр боловсруулан ажиллана.

2.1.8.Жижиг дунд үйлдвэрүүдэд олгож буй зээлийн орон эх үүсвэрүүдийг нэгтгэн зангидаж үйл ажиллагааг үр дүнтэй болгоно.

2.1.9. Олон улсын байгууллагуудын хэрэгжүүлж буй эдийн засаг, ЖДҮ-г хөгжүүлэх чиглэлийн төсөл хөтөлбөрүүдийн уялдааг хангах, үр ашгийг сайжруулахад анхаарч ажиллана.

2.1.10. Эко аялал, хилийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлд орон нутгийн бодлогыг чиглүүлнэ.

2.1.11. Эрчимжсэн мал аж ахуй хөгжих таатай орчинг бүрдүүлнэ.

2.1.12. Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлэх бүс нутгийн тодорхойлж орон нутгийн тусгай хэрэгцээнд авах замаар газрын асуудлыг шийдвэрлэх стратегийг дэмжин ажиллана.

2.1.13. Байгалийн цогцолбор болон түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалах, тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлэх чиглэлд анхаарч ажиллана.

## **ГУРАВ: ЭРҮҮЛ НИЙГЭМ**

### **3.1. Эрүүл иргэн-Эрүүл нийгэм**

3.1.1. Иргэд өөрсдийн амьдрах орчноо сайжруулах, ногоон орчин бий болгох, мод тарих үйл хэргийг төрийн урамшууллын бодлогоор дэмжих тогтолцоог бий болгоно.

3.1.2. Суурин газрын газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах тогтолцоог бий болгоно.

3.1.3. Хүнс нь эм болохуйц эм нь хүнс байхуйц эрүүл мэндийн бодлогыг санаачлан ажиллана.

3.1.4. Өвдсөний дараа бус, өвдөхөөс урьдчилан сэргийлдэг тогтолцоог бүрдүүлэхэд анхаарч ажиллана.

3.1.5. Хоол хүнс, ахуй, хүний амьдрах зан үйлээс үүдэлтэй халдварт бус өвчнийг эрс бууруулах чиглэлд анхаарч ажиллана.

3.1.6. Хүнсний бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхой болгох, боловсруулах бүх шатанд эрүүл аюулгүй байдлыг хангах тогтолцоог дэвшилтэт технологи ашиглаж олон улсын стандартад нийцүүлнэ.

3.1.7. Нийгмийн халамж шаардсан бүлэгт төрийн үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлд хяналт тавьж ажиллана.

3.1.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх стандартыг сайжруулах, амьдралд хэрэгжүүлэх, мөрдүүлэх чиглэлд хяналт тавьж ажиллана.

